

ГАДААД ОЮУТНЫ ХӨТӨЛБӨР

Лос Анжелес Харбор Коллеж нь гадаад оюутнуудыг өөрийн сургуульдаа суралцахыг урьж байна. Тэ энэ нүүрнээс гадаад оюутнууд F 1 визээр суралцах тухай мэдээлэлтэй танилцана уу.

Харбор Коллеж бол 2 жилийн сургалттай олон нийтийн коллеж юм бөгөөд Лос Анжелесийн олон нийтийн сүлжээний 9 коллежийн нэг, Калифорни дахь 100 гаруй олон нийтийн коллежийн нэг бөлгөө. Бид Ассошиат Арт зэрэг олгох, оюутнуудыг цаашдын 4 жилийн сургалттай их дээд сургууль, коллежид шилжин суралцахад бэлтгэдэг. Түүнчлэн зарим мэргэжлийн сертификат, Шинжлэх Ухааны Ассошиат зэрэг олгох 2-жилийн сургалт явуулдаг.

F-1 визний статусын нөхцөл:

F-1 визний статустайгаар Лос Анжелес Харбор Коллежид суралцахын тулд та дараах шаардлагуудыг хангах ёстой.

1. АНУ-ын бүрэн дунд сургуулийн боловсролтой тэнцэхүйц боловсрол эзэмшсэн байх. **(Дүнгийн албан ёсны англи хэлний орчуулга шаардлагатай).**
2. Англи хэлний тодорхой мэдлэгтэй байх. TOЭФЛ-ийн шалгалтын бичгийн **450, компьютерийн 133, интернетийн 45-аас дээш оноо шаардана. IELTS-ийн 5-р түвшиний оноог мөн хүлээн зөвшөөрөх ба хэрвээ та дунд сургуульдаа англи хэл үзсэн бол энэ шаардлагаас чөлөөлөгдөх боломжтой.**
3. **Оюутны санхүүгийн ивээн тэтгэгч, эцэг эх нь хөрөнгийн баталгааг гаргах ёстой. (Банкны баьалгаа юмуу орлогын татварын баримтны хуулбар байж болно.)

** Хэрвээ оюутан өөрийн санхүүг хариуцах чадвартай бол энэ шаардлагаас чөлөөлөгдөх боломжтой ба тухайн оюутан хангалттай санхүүгийн бичиг, банкны баталгаатай байх ёстой.

Санхүүгийн шаардлага:

Нэгдсэн Улсын Гааль, Цагаачлалын Албанаас F-1 визтэй оюутнуудыг АНУ-д суралцах хугацаандаа ажиллахыг зөвшөөрдөггүй бөгөөд манай коллеж санхүүгийн тэтгэлэг олгодоггүй учир тухайн гадаад оюутан нь эхний болон дараагийн жилийн сургалт, амьдралын зардлын санхүүгийн баталгааг зайлшгүй гаргах ёстой. Энэхүү санхүүг эцэг эх, хамаатан, ивээн тэтгэгч, оюутан өөрөөсвэл хамтран гаргаж болно.

Амьдрах байр:

Манай коллеж оюутны дотуур байргүй учир шинээр ирж буй оюутнууд ихэвчлэн **Best Western** зочид буудалд юмуу Сан Педро дахь оюутны буудалд эхний хэдэн хоногтоо байрладаг бөгөөд цаашид байнгын оршин амьдрах байрыг 2-4 хоногт зохицуулдаг. Гадаад оюутны алба сургуультай ойролцоох байрны жагсаалт, мэдээллээр хангана. Суралцах хугацаандаа Америк айлд амьдрах талаар айлд байрлуулах **агентлагуудтай** холбогдож болно.

Энэ холбоос хаягаар **Сан Педро Залуучуудын буудлын** талаар мэдээллийг авах боломжтой. Энэ нүүрлүү буцаж ороходоо ухрах товчлуур дээр дарна уу.

Бүтэн нэг жилийн зардлыг дараах байдлаар ерөнхийлан тооцов:

Сургуультай холбогдох зардал:

F-1 визтэй оюутнууд нэг семестерт 12-оос дээш хичээлд суух ёстой.

	семестер	жилийн
Сургалтын зардал (\$183.00*нэг кредит x 12)	\$2,196.00	\$4,392.00
Элсэлтийн хураамж (\$20.00 нэг кредит x 12)	240.00	480.00
SEVIS-ийн төлбөр	25.00	50.00
Эрүүл мэндийн төлбөр (\$11.00) заавал	11.00	22.00
ОХ-ны гишүүнчлэлийн төлбөр (зайлшгүй)	1.00	2.00
Оюутны Холбооны хураамж (\$7.00)	7.00	14.00
Ном, хангамж (ойролцоогоор)	300.00	600.00
Машины талбайн хураамж	10.00	20.00
Эрүүл мэндийн даатгал (тооцсон)	**420.00	84000
НИЙТ	\$3,210.00	\$6,420.00

**Гадаад оюутны сургалтын зардал нь Лос Анжелесийн Нийгмийн Коллежийн сүлжээнээс жил бүрийн 7 сарын нэгнээр өөрчлөгдөх боломжтой.*

Эрүүл Мэндийн даатгал** - Жил бүрийн нэг сард өөрчлөгдөх боломжтой.

Гадаад оюутнууд Лос Анжелесийн нийтийн коллежийн сүлжээнээс баталсан эрүүл мэндийн даатгалд зайлшгүй хамрагдах ёстой. Эрүүл мэндийн даатгалын төлбөрийг намар, хаврын семестрийн төлбөрт багтаах ба нэг даатгалын хугацаа 6 сар байна. Энэхүү зардал нь бусад коллежийн тухайн зардалтай ойролцоо юм.

Амьдралын өртөг:

(Хоол, байр, хувийн зардал) ойролцоогоор сарын **\$800-аас \$1,000**. Хичээлийн нэг жилийн нийт зардал \$14,920-\$18,000 болно.

F-1 ВИЗНИЙ СТАТУСТАЙГААР ОЮУТНЫ ЭСЭЛТИЙН ЖУРАМ:

Оюутнууд дараах бичиг баримт бүрдүүлсэн байх шаардлагатай:

1. **Гадаад оюутны Элсэлтийн Өргөдөл.**
2. ТОЭФЛ-ийн шалгалтын бичгийн 450ь компьютерийн 133, интернетийн 45 юмуу АЙЛТС-ийн 5-аас дээш онооны албан ёсны бичиг.
3. **Дүнгийн хуулбар** – Бүрэн дунд сургуулийн болон бусад сургууль, коллежийн англи хэлний албан ёсны орчуулга.
4. **Сүүлийн 6 сарын дотор авхуулсан паспортны хэмжээтэй 2 хувь цээж зураг**
5. **Гадаад оюутны гэрээнд гарын үсэг зурсан хуулбар**
6. **Хөрөнгийн баталгаа** – оюутны нэг жилийн сургалтын зардал болох \$14,402-оос дээш хэмжээний хөрөнгийн баталгаа харуулсан бичиг баримтыг ивээн тэтгэгч, эцэг эх нь гаргах.
7. **Өргөдлийн хураамж - \$35.00-** Буцаахгүй. * *Хэрвээ оюутан хөрөнгийн баталгаагаа өөрөө гаргасан тохиолдолд ивээн тэтгэгчийн бичиг шаардлагагүй.*

ТОВЛОСОН ХУГАЦАА:

Бүх бичиг баримтаа бүрдүүлсний дараа дараах товлосон хугацаанд багтааж илгээнэ үү:

Тухайн жилийн Намрын семестерт 6 сарын 15-ны дотор, хаврын семестерт 12 сарын 15-ны дотор бичиг баримтаа илгээх ёстой. (Шилжин суралцаж буй оюутнууд түвшин тогтоох шалгалт, гадаад оюутны өдөрлөгт оролцох боломжтой, хичээлээ сонгох боломжтой тохиолдолд хичээл эхлэхээс 7 хоногийн өмнө өргөдлөө гаргах боломжтой. Өргөдөл гаргагчийн статусын өөрчлөлтийн талаар болон бусад журам, нөхцлийн талаар гадаад оюутны зөвлөгчтэй холбогдох ёстой.)

Лос Анжелес Харбор Коллежид элссэн оюутнууд зуны сургалтанд хамрагдаж болох боловч I-20 бичгийг зуны сургалтаар эхэлж орж байгаа оюутнуудад олгохгүй болно.

Бүх бичиг баримтыг хүлээн авч танилцсаны дараагаар I-20 бичгийг тухайн оюутанд илгээх ба элчингийн ярилцлаганд хэрхэн орох зааварчилгааг мөн хавсарган явуулах болно. Элчингийн ярилцлаганд очихдоо албан урилга, хөрөнгийн баталгаа, боловсролын гэрчилгээнүүдээ авч очих бөгөөд АНУ-ын элчингийн консул тухайн оюутанд виз олгох эсэхийг шийднэ. (Элчингийн ярилцлаганд 120 хүртэл өдрийн өмнө орж болох боловч виз гарсан тохиолдолд АНУ-д зөвхөн 30 хоногийн өмнө нэвтрэх эрхтэй болно.)

Бусад төрлийн визтэй хүмүүс тодорхой хязгаарлалт, нөхцөлтэй. Нарийвчилсан мэдээллийн талаар Гадаад Оюутны Албатай холбогдоно уу.

Лос Анжелес Харбор Коллежийн хичээлийн жил 8 сарын сүүлээр юмуу 9 сарын эхээр эхэлдэг. Хаврын семестер 1 сарын сүүл эсвэл 2 сарын эхээр эхэлнэ.

Оюутнууд хамгийн багадаа хичээл эхлэхээс 15 хоногийн өмнө хүрэлцэн ирсэн байх шаардлагатай бөгөөд эс бөгөөс шаардлагатай, сонирхсон хичээлээ авах боломжгүй байх боломжтой.

АМЬДРАХ БАЙР/БАЙРЛУУЛАХ: Лос Анжелес Харбор Коллеж нь өөрийн сургууль дээр байрлуулах байргүй. Гэсэн хэдий ч Оюутны үйлчилгээний алба, Гадаад оюутны алба нь ойролцоох байрны талаар байнгын мэдээлэлтэй байдаг.

Хэрвээ танд айлд байрлах, байр хөлслөх талаар Харбор Коллеж дээр ирэхээсээ өмнө мэдэх шаардлагатай бол хавсралт захианд буй агентлагуудтай урьдчилан тусдаа холбогдож болно. Учир нь эдгээр агентлаг, байгууллагууд нь бие даасан байгууллага учраас Лос Анжелес Харбор Коллеж аль нэгийг нь батлан хэлэх боломжгүй юм. Эдгээр байгууллагуудтай бие даан хийсэн альваа гэрээ хэлэлцээртээ Лос Анжелес Харбор Коллеж биш, та өөрөө хариуцлага хүлээх болно. Хэрвээ эдгээр байгууллагуудаас үйлчилгээ авч байгаа бол бүгд онгоцны буудлаас тосож авах төлбөрт үйлчилгээ явуулдаг.

Хэрвээ бие даан төвхнөхөөр шийдсэн бол дараах алхамуудыг дагаж болно. Үүнд:

1. Эхэлж ирэхдээ түр байрлах байраа урьдчилан захиалах хэрэгтэй. Гэрээсээ гарахаасаа өмнө заавал захиалгаа хийсэн байх хэрэгтэй. Хамгийн хямд байрлах газар бол Сан Педро дахь Олон Улсын Буудал, хоногийн 23\$. Энэхүү буудал 6/13/2005-аас 10 сар хүртэл нээлттэй байх бөгөөд Gaffey St., Bldg. 613, San Pedro, CA 90731 хаяг дээр байрладаг. Утас нь (310) 831-8109; факсын дугаар нь (310) 831-4635. Энэ буудлын давуу тал нь хямдхан, далайн эргийн байгалийн үзэсгэлэнтэй газар байрладаг бөгөөд ажилчид нь дэндүү тусч хүмүүс. Сул тал нь гэвэл тэнд зөвхөн 7 хоног байрлах боломжтой, нэг юмуу нийтийн байранд бусад хүмүүсийн хамт байрлана, коллеж хүртлээ хоёр автобус дамжих хэрэгтэй. Харин Wilmington-д байрлах Best Western илүү үнэтэй, хэд алхаад л коллежруу орох боломжтой. Энэ буудал 1402 West Pacific Coast Highway, Wilmington, CA 90744 байрладаг. Утас нь (310) 834-3400, факс нь (310) 835-2225. Үүний давуу тал нь өөрийн унтлагын өрөө, угаалгын өрөөтэй, коллежоос 10 минут алхах зайнд байрладаг. Дутагдалтай тал нь илүү үнэтэй, хоногийн \$60.00 нэмээд татвар, 4 долоо хоног хүртэл хугацаагаар байрлах боломжтой. Буудлын ердийн тариф нь нэг өрөө хоногийн ойролцоогоор \$80 байдаг бөгөөд хэрвээ буудлын менежерт Лос Анжелес Харбор Коллежийн шинэ оюутан гэдгээ хэлсэн тохиолдолд 60\$ болох боломжтой юм.)
 2. Лос Анжелесийн Олон Улсын Нисэх Буудал дээр ирээд такси (үнэ нь:\$20-30) юмуу микро автобус (үнэ нь ойролцоогоор: \$20) авч Сан Педро дахь эсвэл Вилтингтон дахь буудал дээр ирэх боломжтой.
- Үргэлжлэл
3. Ирсэн даруйдаа Лос Анжелес Харбор Коллеж дээрх Гадаад Оюутны Алба дээр ирэх хэрэгтэй. Бид удирдлагын байрны 108 тоот өрөөнд

байрладаг. Та эхлээд мөн утасдаж болно. Манай утас (310) 233-4111. Гадаад оюутан хүлээж авах өдрийг хүртэл хүлээсний хэрэггүй. Хэрвээ та Лос Анжелест байгаа л бол та ирээд тохирох хичээлээ аваад явж болно.

4. Хэрвээ та коллеж дээр байгаа бол байрлах байрны жагсаалт зэрэг бусад мэдээллийг үзэх боломжтой. Гэсэн ч түрээслүүлэгч эзэнтэй уулзах зэрэг асуудал бол таны ажил. (Зарим тохиолдолд ьүрээслүүлэгч эзэд зээллэг, гэрээнд гарын үсэг зурахыг шаарддаг. Хэрвээ тэр гэрээнд нь ойлгомжгүй асуудал байгаа бол гарын үсэг битгий зураарай. Гадаад оюутны албанд ир, бид таньд ойлгомжтой, эрсдэлгүй байдлаар гэрээтэй харьцахад чинь туслах болно.)

Бэлэн мөнгө авч явах: Америкчууд голдуу бага хэмжээний бэлэн мөнгө биедээ авч явдаг. Ихэвчлэн 5-50 доллар кармандаа байлгах ба чек, зээлийн кард, АТМ машин зэргийг 50-аас дээш хэмжээний гүйлгээ хийхдээ хэрэглэдэг. Мэдээж таныг анх Америкт ирэхэд бэлэн мөнгө хэрэгтэй ч биедээ их хэмжээний мөнгө авч явахгүй байхыг эрхэмлэх хэрэгтэй. Ерөнхийдөө нэг, хоёр зуун доллар эхний хэдэн өдөр эргэн тойронд гарахад хэрэг болно. Магадгүй нэг зуун доллар ч хангалттай байж болох юм. Бусад мөнгөө аялагчийн чек юмуу мөнгөний өөр хэлбэрээр авч ирвэл зохимжтой.